



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/54/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Х.Манаргүл

Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	Error! Bookmark not defined.
5.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
5.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

**ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 8 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.АРМАНГУЛ ТАНАА**

2024.02.08 № 57
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд онцлох үйл явдал гараагүй байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал

00402039

байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.АЙГУЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29,479,007.16</u>	<u>23,038,773.86</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	24,591,990.16	19,446,056.86
3121	Төгрөг	24,591,990.16	19,446,056.86
31211	Төрийн сангийн харилцах	24,591,990.16	19,446,056.86
33	АВЛАГА	-	879,800.00
335	Бусад авлага	-	879,800.00
3351	Байгууллагаас авах авлага	-	32,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	847,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,887,017.00	2,712,917.00
354	Хангамжийн материал	4,887,017.00	2,712,917.00
35420	Аж ахуйн материал	2,533,400.00	-
35440	Түлш, шатах тослох материал	234,000.00	541,000.00
35460	Хүнсний материал	244,000.00	296,300.00
35470	Бусад хангамжийн материал	1,875,617.00	1,875,617.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>79,263,233.84</u>	<u>91,820,784.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	79,263,233.84	91,820,784.60
392	Биет хөрөнгө	78,715,833.84	89,945,028.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	38,185,614.00	38,185,614.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,933,501.02)	(5,300,641.34)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,778,715.00	62,819,876.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,450,768.27)	(15,528,664.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,648,644.00	3,983,010.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,000,023.87)	(1,676,539.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,312,050.00	1,497,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,163,370.00)	(1,373,400.00)
39217	Ном	7,338,474.00	7,338,474.00
393	Биет бус хөрөнгө	547,400.00	1,875,756.40
39301	Програм хангамж	550,000.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(644,882.60)
39303	Бусад биет бус хөрөнгө	547,400.00	547,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>108,742,241.00</u>	<u>114,859,558.46</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>108,742,241.00</u>	<u>114,859,558.46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	108,742,241.00	114,859,558.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	37,821,898.00	37,821,898.00
51101	Өмч: - төрийн	37,821,898.00	37,821,898.00
512	Хуримтлагдсан үр дүн	60,377,182.28	66,494,499.74
51210	Өмнөх үеийн үр дүн	60,377,182.28	60,377,182.28
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,117,317.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,543,160.72	10,543,160.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>108,742,241.00</u>	<u>114,859,558.46</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	307,212,400.00	312,761,287.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	150,648.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	150,648.00
120009	Бусад орлого	-	150,648.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	307,212,400.00	312,610,639.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	281,273,800.00	301,420,239.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	259,150,800.00	295,641,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	22,123,000.00	5,779,239.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,938,600.00	11,190,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,938,600.00	11,190,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	261,589,142.83	306,643,969.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,589,142.83	306,643,969.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	241,373,092.02	294,111,664.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,799,329.03	235,687,242.76
210101	Үндсэн цалин	154,062,189.56	166,363,114.80
210102	Нэмэгдэл	31,787,443.09	55,794,275.96
210104	Урамшуулал	2,949,696.38	10,547,692.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	2,982,160.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,420,900.00	29,789,588.54
210201	Тэтгэврийн даатгал	18,033,700.00	19,598,826.57
210202	Тэтгэмжийн даатгал	2,046,700.00	2,501,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,690,900.00	2,001,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	422,400.00	500,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,227,200.00	5,187,761.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,809,900.00	10,382,845.45
210301	Гэрэл, цахилгаан	750,400.00	2,573,845.45
210302	Түлш, халаалт	6,559,500.00	5,309,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,013,080.00	-
210401	Бичиг хэрэг	2,542,900.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,470,180.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	900,850.00	500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	651,050.00	-
210604	Урсгал засвар	249,800.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,602,900.00	930,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,602,900.00	930,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,826,132.99	16,821,588.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,807,400.00	5,109,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,332,000.00

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,018,732.99	10,380,388.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,216,050.81	12,532,304.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,216,034.81	12,531,750.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,416,170.00	12,531,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,799,864.81	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16.00	554.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16.00	554.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>45,623,257.17</u>	<u>6,117,317.46</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>45,623,257.17</u>	<u>6,117,317.46</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>285,089,400.00</u>	<u>306,982,048.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	150,648.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	150,648.00
120009	Бусад орлого		150,648.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	285,089,400.00	306,831,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	259,150,800.00	295,641,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	259,150,800.00	295,641,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,938,600.00	11,190,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,938,600.00	11,190,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>254,828,409.84</u>	<u>294,969,281.30</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	254,828,409.84	294,969,281.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	237,639,393.84	282,384,676.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	189,970,393.84	236,567,042.76
210101	Үндсэн цалин	147,909,633.46	167,242,914.80
210102	Нэмэгдэл	38,173,760.38	58,801,437.96
210104	Урамшуулал	3,887,000.00	10,522,690.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,420,900.00	29,789,588.54
210201	Тэтгэврийн даатгал	17,966,400.00	19,782,988.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,114,000.00	2,501,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,690,900.00	2,001,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	422,400.00	500,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,227,200.00	5,003,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,490,400.00	10,689,845.45
210301	Гэрэл, цахилгаан	1,374,400.00	2,573,845.45
210302	Түлш, халаалт	5,616,000.00	5,616,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,500,000.00

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,511,800.00	888,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,511,800.00	888,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,745,900.00	3,950,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,351,200.00	2,618,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,394,700.00	1,332,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,189,016.00	12,584,604.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,189,000.00	12,584,050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,560,200.00	12,584,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,628,800.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16.00	554.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16.00	554.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>30,260,990.16</u>	<u>12,012,766.70</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,669,000.00	17,158,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,669,000.00	17,158,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,669,000.00	17,158,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,669,000.00	17,158,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,669,000.00)</u>	<u>(17,158,700.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	24,591,990.16	(5,145,933.30)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		24,591,990.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,591,990.16	19,446,056.86

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	37,821,898.00	10,543,160.72	60,377,182.28	108,742,241.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,821,898.00	10,543,160.72	60,377,182.28	108,742,241.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-

D08	Тайлант үеийн үр дүн			6,117,317.46	6,117,317.46
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,821,898.00	10,543,160.72	66,494,499.74	114,859,558.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	331,574,000.00	311,976,778.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	331,574,000.00	311,976,778.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,778,300.00	299,392,728.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,695,800.00	236,751,204.73
210101	Үндсэн цалин	174,666,500.00	167,427,076.77
210102	Нэмэгдэл	68,899,100.00	58,801,437.96
210104	Урамшуулал	9,130,200.00	10,522,690.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,587,200.00	29,605,426.57
210201	Тэтгэврийн даатгал	21,479,300.00	19,598,826.57
210202	Тэтгэмжийн даатгал	2,527,000.00	2,501,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,021,600.00	2,001,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	505,400.00	500,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,053,900.00	5,003,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,690,400.00	10,689,845.45
210301	Гэрэл, цахилгаан	2,574,400.00	2,573,845.45
210302	Түлш, халаалт	5,616,000.00	5,616,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	888,000.00	888,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	888,000.00	888,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,416,900.00	20,958,252.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,084,900.00	19,626,252.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,332,000.00	1,332,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,795,700.00	12,584,050.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,795,700.00	12,584,050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,795,700.00	12,584,050.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	306,831,400.00	306,830,845.45
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	295,641,000.00	295,641,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	295,641,000.00	295,641,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,190,400.00	11,189,845.45
132001	Орон нутгийн төсвөөс	11,190,400.00	11,189,845.45
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		24,591,990.16
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17.00	17.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00

620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	8.00	8.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	8.00	8.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тус байгууллагад нэмэлт данс байхгүй байна

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь бага боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага. " Боловсролын үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх стандартад суурилсан боловсрол олгох, эрүүл чийрэг хүүхэд төлөвшүүлэх" зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Өлгий сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулж, захирлын тушаалаар батлуулан мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.1 сая төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24,592.0	19,446.1	(5,145.9)
Авлага	-	879.8	879.8
Бараа материал	4,887.0	2,712.9	(2,174.1)
Үндсэн хөрөнгө	79,263.2	91,820.8	12,557.6
Нийт хөрөнгө	108,742.2	114,859.6	6,117.3
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	108,742.2	114,859.6	6,117.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	108,742.2	114,859.6	6,117.3

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 19.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь цалингийн зардлаас 15.9 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 2.0 сая, бараа үйлчилгээний бусад зардлаас 0.5 сая, бусад урсгал шилжүүлгийн зардлаас 1.2 сая төгрөг үлдсэн мөнгө байна.

Авлагын дансны үлдэгдэл 0.8 сая төгрөг байгаа нь ажиллагсадтай холбоотой авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.7 сая төгрөг болж 2.2 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 22.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 21.4 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 116.3 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр өссөн нь 17.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр “Бодь электроникс ХХК”-аас 17.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг цахим буюу ерөнхий гэрээний дагуу худалдан авалт хийсэн байна.

Тайлант онд 6.1 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 6.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 234.6 сая, нийт зарлагыг 234.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 61.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 295.6 сая төгрөгөөр баталсан байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны анх батлагдсан төсөв 254.2 сая төгрөг ба тодотгосон төсөв 295.6 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсанаас 41.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үүнд: ажиллагсадтай холбоотой зардлыг 40.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бараа үйлчилгээний бусад зардал 1.4 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Ерөнхий боловсрол гэсэн 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 295.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 11.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүгд 307.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 295.6 сая, орон нутгийн төсвөөс 11.2 сая бүгд 306.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урьд оны үлдэгдэлээс 24.7 сая төгрөг зарцуулсан байна. Төсвийн зарлагын нийт гүйцэтгэл 312.0 сая төгрөг буюу 94.1 хувьтай буюу дансанд 19.4 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардал бүрээр авч үздэл цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал 236.8 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 29.6 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 10.7 сая, эд хогшил, урсгал засварын зардал 0.5 сая, бусад бараа үйлчилгээний зардал 0.9 сая, бараа үйлчилгээний бусад зардал 20.9 сая, урсгал шилжүүлэг 12.6 сая бүгд 312.0 сая төгрөг байна.

Нийт төсвийн зарлагын 72.4 хувийг цалингийн зардал, 10.1 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3.6 хувийг, эд хогшил, урсгал засварын зардал 0.1 хувийг, бараа үйлчилгээний бусад зардал 13.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	383.6	383.6	-	100.0
80312	Сургалт семинар	177.6	177.6	-	100.0
81605	Эрүүл мэндийг дэмжих	355.2	355.2	-	100.0
81801	Үдийн цай хөтөлбөр	13,795.7	12,584.1	1,211.7	91.2
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	17,158.7	17,158.7	-	100.0
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	799.2	799.2	-	100.0
81834	Боловсролын стандарт, сургалты	199,096.6	188,419.0	10,677.6	94.6
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	88,466.4	80,909.6	7,556.8	91.5
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	11,190.4	11,190.4	-	100.0
	Дүн	331,423.4	311,977.4	19,446.0	94.1

Сургуулийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 19.4 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: боловсролын стандарт, сургалт 10.7 сая, сургалтын хэвийн үйл ажиллагаа 7.5 сая, үдийн цай хөтөлбөр 1.2 сая төгрөг төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сургууль нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 22.2 сая төгрөгийн бараа материал, 17.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий ймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБООУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 307.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2023 онд нийт 786.7 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75% байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулаагүй байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2023 онд нийт 305.2 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь байна. Мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг бүрэн байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд ямар нэгэн хяналт хийгэгдээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 149.6 сая төгрөгийн зөрчил илэрч 2.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 116.2 сая төгрөгийн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах 2 албан шаардлага, 31.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөв хүргүүлсэн. Үүнд:

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	/мянган төгрөгөөр/	
				Дүн	Хувь
Акт	2	2081.0	2	2081.0	100%
Албан шаардлага	3	116250.5	3	116250.5	100%
Зөвлөмж	4	31408.4	4	31408.4	100%
Нийт дүн	9	149739.9	9	149739.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 0.6 сая төгрөгийн алдаа илэрч залруулга хийсэн. Үүнд: МГТайлан, ҮДТайланд цалингийн зардлыг 0.4 сая төгрөгөөр, төсвийн гүцэтгэлийн тайлангийн эх үүсвэрийг 0.2 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасныг залруулав.

5.1 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

5.3 Зөвлөмж

Зөвлөмж байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
БТ, ТГТ, ҮДТ, МГТ-уудад залруулсан	6	582.9					6	582.9				
ДҮН	6	582.9					6	582.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								